



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Газрын дарга: С.Энхзаяа

Утас: 261663

Цахим хаяг:

enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: С. Оюунгэрэл

Утас: 260512

Цахим хаяг:

oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор : Г.Юра

Утас: 263813

Цахим хаяг:

yurag@audit.gov.mn

Үндэсний Аудитын Газар

Засгийн газрын IY байр

Бага тойруу 3

Улаанбаатар-46

Монгол улс

Цахим хуудас: www.audit.mn

Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

АГУУЛГА

Оршил

Санхүүгийн дотоод хяналт

Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Аудитын санал дүгнэлт

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

2013 оны 4 дүгээр сар

Оршил

Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитыг дуусгавар болгосон тухай энэхүү тайланг Батлан хамгаалах яамны удирдлагад танилцуулж байна.

Батлан хамгаалахын сайдын нийт төсөвт зардлын 90.1 хувийг хамарсан санхүүгийн тайланд Үндэсний аудитын газар, 9.9 хувийг хамарсан санхүүгийн тайланд болон санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүнд багтдаг Батлан хамгаалахын их сургууль, Батлан хамгаалах хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлэг, Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга, Монгол цэргийн музей, Батлан хамгаалахын эмгэг судлал шүүх эмнэлэг, Багабаян-Энхийн төлөө цогцолбор төв, Барилга захиалагчийн алба, Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл, Транс сэргэлт, Бөртэ ТӨҮГ-уудын санхүүгийн тайланд хараат бус аудитын компаниуд тус тус аудит хийж гүйцэтгэлээ.

Батлан хамгаалах яамны аппарат, Батлан хамгаалахын төв архив, Батлан хамгаалахын эмгэг судлал, шүүх эмнэлэг, Зэвсэгт хүчний нийт 31 анги салбарын 2013 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт ирүүлснийг аудитын явцад түүвэрт хамруулсан болно.

Зэвсэгт хүчний 016, 119, 338, дүгээр ангиудын 2013 оны санхүүгийн тайланг аймаг, орон нутгийн Аудитын газруудаар аудит хийлгээгүй байна.

Аудитаар Транс сэргэлт, Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨҮГ-уудын санхүүгийн тайланд “хязгаарлалттай”, Монгол цэрэг жуулчин ТӨҮГ-ын санхүүгийн тайланд “сөрөг”, бусад байгууллагуудын санхүүгийн тайланд “зөрчилгүй” санал дүгнэлт өгөгдсөн байна.

Менежментийн захидалд санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах талаар бидний зүгээс өгч буй зөвлөмжүүд болон уг зөвлөмжийн талаар БХЯ-наас ирүүлсэн хариуг тусгасан болно.

Санхүүгийн дотоод хяналт

Батлан хамгаалах яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас батлан хамгаалах салбарын гадаад арга хэмжээний төсвийн зарцуулалт, БХЯ-ны төсөв, хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн 2013 оны эхний хагас жилийн гүйцэтгэл, “Монгол цэрэг констракшн”, “Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл” ТӨҮГ-ын 2013 оны эхний 9 сарын санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийж дүгнэлт гаргасан байна.

Мөн Зэвсэгт хүчний Хяналт шалгалт, үнэлгээний газрын Санхүүгийн хяналтын албанаас 2013 онд Зэвсэгт хүчний 232, 310, 338, 186, 326 дугаар ангийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд бүрэн хэмжээний, Зэвсэгт хүчний 013, 119

дүгээр ангийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хэсэгчилсэн шалгалт, ЗХЖШ-ын даргын болон ХШҮГ-ын даргын өгсөн үүргийн дагуу Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн мөнгөн хөрөнгийн гүйлгээ, гэрээ, түрээсийн орлогын бүрдүүлэлт, байгууллага хоорондын тооцоо, цэргийн хангалтын нормын биелэлтэд хяналт тавьж, Зэвсэгт хүчний хэрэгцээт мал, мах бэлтгэлийн явц, Зэвсэгт хүчний 232, 310 дугаар ангийн шалгалтын актын биелэлтэд гүйцэтгэлийн хяналт шалгалт явуулсан байна.

Шалгалтын дүнгээр нийт 699.3 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 520.5 сая төгрөгийг холбогдох хүмүүсээр төлүүлэхээр акт тогтоож, тайлангийн хугацаанд 357.6 сая төгрөгийн төлбөр зөрчлийг барагдуулж ажилласан байна.

Түүнчлэн Бөртэ ТӨҮГ-ын 2010, 2011, 2012 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас, Монгол цэрэг констракшн ТӨҮГ-ын 2013 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас тус тус шалгалт хийсэн байна.

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Ийнхүү дахин хянахдаа Батлан хамгаалах яамны хяналтыг санхүүгийн хяналтын эрсдэл, хяналтын талаарх өөрийн мэдээллийн сантай харьцуулан шинжилгээ хийсэн.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах боломж олгосон.

Тухайн жилд асуудал үүсгэсэн эдгээр хяналтыг бид Батлан хамгаалахын сайдад танилцуулж байна.

Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд

Батлан хамгаалахын төсвийн шууд захирагч 8, төвлөрүүлэн захирагч 1, тусгай сан 1, төрийн өмчит үйлдэрийн газар 6, нийт 16 байгууллагуудад аудитаар илэрсэн алдаа зөрчлийг нэгтгэн дараах байдлаар хураангуйлан тэмдэглэв.

Нэг. Батлан хамгаалахын сайдын нэгтгэсэн санхүүгийн тайлан, тусгай санд хийсэн аудитаар илэрсэн зөрчил дутагдлын талаар.

✚ Батлан хамгаалахын сайдын нэгтгэсэн санхүүгийн тайлан

- Батлан хамгаалахын сайдын хамрах хүрээний байгууллагуудын дүнгээр авлага өмнөх оноос 43.0 хувиар буюу 1,370.0 сая төгрөгөөр буурсан хэдий ч өр төлбөр өмнөх оноос 3,080.2 сая төгрөгөөр өссөн, нийт авлагын 31.4 хувь буюу 33 байгууллагатай холбоотой 321.4 сая төгрөгийн авлага, нийт өр төлбөрийн 2.7 хувь буюу 131.2 сая төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

- Батлан хамгаалахын сайдын төсвийн багцын зарим байгууллагад анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, бэлэн мөнгөний зарцуулалтын нотлох баримтын бүрдэл хангалтгүй, хөөн хэлэлцэх хугацаа дууссан найдваргүй авлагыг шийдвэрлэж данс бүртгэлээс хасалт хийгээгүй, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулаагүй, төсвийн гүйцэтгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байна.
- Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Засгийн газрын оруулсан капитал дансыг нэмэгдүүлэн бүртгэсэн хандив, буцалтгүй тусламж, дотоод шилжүүлгийн хөрөнгийн нийт 12,443.4 сая төгрөгийг Сангийн сайдын 2013 оны 269 дүгээр тушаалаар баталсан журмын өөрчлөлтийн дагуу, мөн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд Барилга захиалагчийн албаны 28.7 сая, Бөртэ ТӨҮГ-ын 55.3 сая төгрөгийн хасах дүнтэй бичигдэж тайлагнасан гүйлгээг тус тус аудитаар залруулга хийсэн,
- Батлан хамгаалах яамны харьяа Төрийн өмчит үйлдвэрийн газруудын дүнгээр авч үзвэл 2013 онд нийт 190.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

ТӨҮГ-уудын ашиг, алдагдлыг сүүлийн 3 жилээр харуулбал:

| Төрийн өмчит үйлдвэрийн газруудын нэр | /сая төгрөгөөр/ | | |
|---------------------------------------|-----------------|--------------|----------------|
| | 2011 он | 2012 он | 2013 он |
| Бөртэ | 140.4 | 215.6 | 595.1 |
| Транс сэргэлт | 34.2 | (30.0) | (64.7) |
| Багабаян-Энхийн төлөө цогцолбор төв | 6.6 | 4.8 | 11.5 |
| Монгол цэрэг констракшн | 9.6 | (9.8) | (689.8) |
| Барилга захиалагчийн алба | 0.9 | 66.7 | (59.5) |
| Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл | - | - | 16.8 |
| Нийт дүн | 191.7 | 247.2 | (190.7) |

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 63 дугаар тогтоолоор Батлан хамгаалах яамны харьяа аж ахуйн нэгж, байгууллагуудыг үр ашигтай ажиллуулах, нэгдмэл удирдлагаар хангах зорилгоор “Монгол цэрэг констракшн”, “Транс сэргэлт” аж ахуйн тооцоотой ТӨҮГ болон “Батпромимпекс” ХХК-ийг нэгтгэн нэгдсэн зохион байгуулалтад оруулж “Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл” ТӨҮГ болгон өөрчилж БХЯ-ны харьяанд байгуулахаар шийдвэрлэсэн байна.

Зэвсэгт хүчний хөгжлийн сан

- Батлан хамгаалахын сайдын 2012 оны А/121 дүгээр тушаалаар Транс сэргэлт ТӨҮГ-ын валютын харилцах дансанд байршиж байсан гэрээний урьдчилгаа төлбөрийн 2,070.0 мянган ам.долларыг тухайн үеийн ханшаар тооцон 2,716.3

сая төгрөгийг Зэвсэгт хүчний хөгжлийн санд шилжүүлэн урьдчилж орсон орлогоор бүртгэсэн байна. Тус сангийн 2013 оны санхүүгийн тайлангийн аудитаар валютын ханшийн өөрчлөлтөөс үүсэх эрсдэлээс сэргийлж, Монголбанкны жилийн эцсийн албан ханшаар тооцон ханшны зөрүүгийн алдагдал 719.1 сая төгрөгийг нэмж тооцоноор 3,435.2 сая төгрөгийг бусад өглөг дансанд залруулах бичилт хийлгэн тусгуулсан болно.

- Батлан хамгаалахын сайдын 2012 оны А/413 дугаар тушаалаар тус яамны дотор засвар, тохижилтын ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах зардлыг 141.7 сая төгрөгөөр баталж, батлагдсан зардлыг БХЯ-ны 2013 оны урсгал засварын зардлаас гаргаж санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн боловч 94.2 сая төгрөгийг Зэвсэгт хүчний хөгжлийн сангаас зарцуулсан,
- Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 25.1 дүгээр зүйлийн 2.4-д заасныг зөрчиж Батлан хамгаалахын сайдын 2013 оны Б/88 дугаар тушаалаар нэр бүхий 5 хүний шагналын 22.5 сая төгрөгийг зарцуулсан,
- Тус сангаас гадаад томилолт, үнэмлэх хэвлүүлэх, хурлын үйл ажиллагааны зардалтай холбоотой нийт 4.7 сая төгрөгийг бүрдэл дутуу баримтаар зарцуулсан байна.

Хоёр. Төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар.

Зэвсэгт хүчний жанжин штаб

- ЗХЖШ-ын багцын дүнгээр 2013 оны батлагдсан төсвийг 0.2 хувиар буюу 295.6 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан боловч төсвийн гүйцэтгэлийг зардлын нэр төрлөөр авч үзвэл түлш, халаалтын зардлыг 257.8 сая төгрөг, ном хэвлэл худалдан авах, эм, урсгал засвар, биеийн тамирын уралдаан тэмцээн, холбооны суваг ашигласны болон бусад төлбөр хураамжийн зардлыг батлагдсан төсвөөс 2.7-38.3 сая төгрөгөөр, харьяа байгууллагуудаар авч үзвэл Зэвсэгт хүчний 8 анги батлагдсан төсвийг 0.7-27.1 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.
- ЗХЖШ-ын дүнгээр авлага өмнөх оноос 508.9 сая төгрөгөөр буурсан боловч Зэвсэгт хүчний 5 анги 3.3 - 202.6 сая төгрөгийн он дамжсан авлага үүсгэсэн, нэр бүхий 6 ангид 2007 оноос хойш үүссэн 98 хүнтэй холбоотой 186.7 сая төгрөгийн авлагыг барагдуулах асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.
- Тайлант хугацааны эцэст 1,207.4 сая төгрөгийн урьдчилж төлсөн зардлын үлдэгдэлтэй тайлагнаснаас Зэвсэгт хүчний 014, 167, 232, 310, 327, 338, 339 дүгээр анги, Соёмбо сонины газрын нийт 555.4 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.

- 2013 оны жилийн эцсийн тооллогоор нийт 59.9 сая төгрөгийн бараа материал, дутагдсанаас үзэхэд хөрөнгө, материалын хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт төдийлөн сайнгүй байгааг харуулж байна.

Аудитаар Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын төсвийн багцын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн дүнгээр нийт 1,057.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 36 зөвлөмж өгөгдөж, 0.5 сая төгрөг зөрчилд 2 акт тогтоогдсон байна.

Батлан хамгаалах яамны аппарат

- Батлан хамгаалах яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас батлан хамгаалах салбарын гадаад арга хэмжээний төсвийн зарцуулалт, БХЯ-ны төсвийн зарцуулалтад хийсэн аудит болон санхүүгийн тайлангийн өмнөх онуудад хийсэн аудитаар гадаад томилолт, бусад төсөвт арга хэмжээний зардлын тооцоонд мөнгөн урьдчилгааны тайланг гаргуулж байхаар зөвлөмж болгосныг бүрэн хэрэгжүүлээгүйгээс 2013 онд зарим гадаад томилолтын зочид буудал, бэлэг дурсгал, үзвэр, уулзалтын зардлын тооцооны үндсэн баримтыг авч хавсаргаагүйгээс нэр бүхий 10 хүнтэй холбоотой нийт 16.3 сая төгрөгийг баримтын бүрдэлгүйгээр зардлаар бүртгэж тайланд тусгасан байна.

Батлан хамгаалахын төв архив

- Төв архив 2013 онд нийт 16.5 сая төгрөгийн орлоготой ажилласан. Архивын үйлчилгээ, лавлагааны 1000, 2000 төгрөгийн хураамжийн тасалбарыг нягтлан бодогч компьютерт бэлтгэн хэвлэж, гараар дугаарлан няравт хүлээлгэн өгч тооцоог хийж байгаа нь орлогын бүртгэл, тайлан тооцоонд тавих дотоод хяналт алдагдахад хүргэж байна.

Батлан хамгаалахын их сургууль

- 2013 онд ажиллагсдын ажилласан хоногийг илүү, дутуу тооцож байсны улмаас нийт 79 ажиллагсдад 2.3 сая төгрөг илүү, 44 ажилагсдад 1.8 сая төгрөгийн цалинг дутуу олгож, 0.4 сая төгрөгийн ХХОАТ суутгаагүй, томилолтын зардлыг батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй зэрэг зөрчил илэрсэн байна.

Гурав. Төрийн өмчит үйлдвэрийн газруудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар.

1. Бөртэ ТӨҮГ

- Тайлант оны эцэст 65.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнаснаас 15 байгууллагатай холбоотой 8.1 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй,

- Засгийн газрын Тусгай сангийн тухай хуулийн 25.1.4 дүгээр заалтад "улсын хэмжээний бүтээн байгуулалтад цэргийн анги салбар, нэгжийг оролцуулснаас олсон ашгийг сангийн эх үүсвэрт ашиглаж байх" гэж заасныг зөрчин "Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл" ТӨҮГ-т 30.0 сая төгрөг шилжүүлж, оны эцэст авлагаар бүртгэж тайлагнасан байна.

2. Багабаян ТӨҮГ

- Нэгж бүтээгдэхүүний орцын нормыг технологийн картын дагуу тооцдоггүй, худалдаж авсан бараа материалын хэмжээгээр зардалд шингээн бүртгэж тайлагнасан,
- Тайлант хугацаанд нийт 88.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн,
- 2013 оны жилийн эцэст "Сайнчо" ХХК-иас авах 4.5 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй,
- Хувь хүнээр гүйцэтгүүлсэн ажлын хөлсний 45.0 сая төгрөгөөс ХХОАТ-ын 4.5 сая төгрөгийг суутган тооцоогүй байна.

3. Транс сэргэлт ТӨҮГ

- 2012 оны жилийн эцсийн мөнгөн хөрөнгийн журналаас бусад тооцооны данс утсаны улмаас аудитаар 2013 оны эхний үлдэгдлийг баталгаажуулах боломжгүй болсон,
- Тус газрын санхүүгийн тайланд байгууллагаас авах хөөн хэлэлцэх хугацаа дууссан 60.9 сая төгрөгийн авлага бүртгэгдэж байгаагаас ОХУ-ын "Melvale corporation" компаний 27.2 сая төгрөг, "Хар тарвагатай" ХХК-ий 0.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй,
- Тайлант хугацаанд анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 10.6 сая төгрөгийн гүйлгээг шууд зардлаар бүртгэж тайлагнасан,
- Мэргэжлийн жолооч ажиллуулах тухай Транс говь ХХК-тай 2011 онд байгуулсан гэрээний дагуу 2013 онд 39.6 мянган төгрөгийн орлого орсноос Батлан хамгаалахын сайдын 2005 оны 51 дүгээр тушаалаар гэрээний үнийн дүнгийн 5 хувиар орлогоо хүлээн зөвшөөрнө гэж заасныг үндэслэн 14.1 сая төгрөгийг орлогоор хүлээн зөвшөөрч борлуулалтын орлогыг дутуу тайлагнаж ирсэн байна. Энэ нь Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын хуулийн 11.1 дүгээр заалтыг зөрчиж байна.

Дээрх зөрчлийн улмаас тус газрын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах аудитаар "хязгаарлалттай" дүгнэлт өгөгдсөн байна.

4. Монгол цэрэг констракшн ТӨҮГ

- "Круз Интернэйшнл" ХХК-ийн дүрмийн санд оруулсан хөрөнгө оруулалтаас буцаан авсан 200.0 сая төгрөгийг мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын хэсэгт бус нийт орлогод тусгаж тайлагнасан,
- Санхүүгийн тайлан, гүйлгээ балансын үлдэгдэл дүнгээс бараа материалын тооллогын бүртгэлийн дүн 35.4 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэл дэх барилга байгууламж дансны үлдэгдэл дүн 216.4 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй бүртгэгдсэн,
- Машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, бусад үндсэн хөрөнгийн дансдын элэгдлийн тооцооллыг хийгээгүй,
- Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн нисдэг тэрэгний засварын зардлыг БХС-ын А/271 тоот тушаалын дагуу 193.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн бөгөөд уг гүйлгээг орлогын тайланд үйл ажиллагааны зардлаар тайлагнасан,
- Санхүүгийн програмаар бэлтгэгдсэн гүйлгээ балансад стандарт бус үлдэгдэлтэй данс нийтлэг, эдгээрийн үлдэгдэл санхүүгийн тайлантай тохирохгүй, касс харилцахын гүйлгээнээс бусад ажил гүйлгээг санхүүгийн програм хангамжаар гүйцэтгэдэггүй зэрэг зөрчил дутагдал илэрч, улмаар 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах аудитаар "сөрөг" дүгнэлт өгөгдсөн байна.

5. Барилга захиалагчийн алба ТӨҮГ

- Бэлэн мөнгөний зарим баримтын иж бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар гүйлгээ хийсэн, орлого, зардлыг буруу бүртгэсэн,
- Санхүүгийн тайланд хувь хүмүүсээс авах олон жил дамжсан авлага бүртгэгдэж, найдваргүй авлагын нөөц байгуулаагүй,
- Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл данс хасах 28.7 сая төгрөгөөр бүртгэгдэж тайлагнагдсан байна.

6. Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨҮГ

- Тус газрын хэрэглэж буй түлш халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир усны зардлыг БХЯ, ЗХЖШ-ын Үйлчилгээ, аж ахуйн хэлтэс төлж байгаа нь зардлын гүйцэтгэл, санхүүгийн үр дүн бодитоор илэрхийлэгдэхгүй байгаа,
- Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайланд нийт 12,393.0 сая төгрөгийг урьдчилж орсон орлогоор, 12,110.6 сая төгрөгийг урьдчилан гарсан зардлаар бүртгэж тайлагнасан,

- "Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл" ТӨҮГ 2013 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр байгуулагдсанаас хойш бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл нь 2 удаа өөрчлөгдсөн байхад улсын бүртгэлийн гэрчилгээнд холбогдох өөрчлөлтийг бүртгүүлээгүй, байгууллагын дүрмийг шинэчилж батлаагүй, үйл ажиллагааны чиглэл, хэтийн төлөв тодорхой бус зэрэг шалтгааны улмаас 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар "хязгаарлалттай" санал дүгнэлт өгсөн байна.

Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 3,047.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 807.7 сая төгрөгийн залруулга хийгдэж, 46 зөвлөмж, 2 албан шаардалга өгөгдсөн болно.

Санхүүгийн дотоод хяналттай холбоотой илэрсэн зарим асуудал менежментийн захидалтай нийлээд аудитаар илрүүлсэн гол зүйлсийг бүрдүүлж байгаа болно. Эдгээр нь байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа болон ажил гүйлгээнд тавих хяналт төдийлөн хангалттай бус, ажил хариуцсан хүмүүсийн чадвар шаардлагын хэмжээнд хүрэхгүй байгааг харуулж байна.

Дөрөв. Төсвийн гүйцэтгэлийн талаар.

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулиар Батлан хамгаалахын сайдын төсвийн багцын нийт зарлага 163,095.1 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд үүнээс 151,344.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 2,442.3 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 9,308.0 сая төгрөгийг харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Батлан хамгаалахын сайдын төсвийн багцын Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд тайлант хугацаанд нийт 157,671.8 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 33.0 хувь буюу 5,423.3 сая төгрөгөөр хэмнэжээ. Үүнээс урсгал төсвийн 98.9 хувь буюу 143,764.6 сая төгрөгийг зарцуулж, 1,591.4 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Урсгал зардлын дээрх хэмнэлт нь төлбөр хураамж болон бусад зардал 1,159.9 сая төгрөг, тогтмол зардал 110.6 сая төгрөг, нэмэгдэл урамшлын зардал 115.1 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 162.7 сая төгрөгөөр зарцуулагдаагүйтэй холбоотой байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Батлан хамгаалахын сайдын төсвийн багцын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газраас аудит хийж 6 зөвлөмж өгсөнөөс 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 3 зөвлөмжийг хэрэгжих шатанд буюу зөвлөмжийн хэрэгжилт 91.7 хувийн биелэлттэй байна. */Зөвлөмжийн хэрэгжилтийг хавсаргав./*

Аудитын санал дүгнэлт

Бид Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эдгээр стандартад зааснаар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор өмнөх шатанд хийсэн аудитын дүнг үнэлж, нэгтгэх, аудитын түүвэрт хамрагдсан зарим байгууллагын харилцахын болон бусад анхан шатны баримтыг дэлгэрэнгүй, хураангуй бүртгэл, тайлангийн зохих үзүүлэлтүүдтэй тулган шалгав.

Салбарын хэмжээний 2013 оны нийт зардлын гүйцэтгэлийг материаллаг байдлын суурь үзүүлэлт болгож, аудитын явцад тооцсон эрсдэлийг харгалзаж материаллаг байдлын түвшинг суурь үзүүлэлтийн 2 хувиар тооцсон болно.

Батлан хамгаалахын сайдын хамрах хүрээний байгуулагуудын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь материаллаг зүйлсийн хувьд Монгол Улсад мөрдөж байгаа стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөвөөр илэрхийлсэн байна гэж үзэж “зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210046 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.25 № 699

тантай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Батлан хамгаалахын сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Батлан хамгаалах яамны удирдлага Төсвийн тухай хуульд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.


Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Батлан хамгаалахын сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР  А.ЗАНГАД



070483

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН



Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1

Асуудал 1

Авлага, өр төлбөрийн баталгаажилтын талаар

Асуудал 2

Валютын ханшийн зөрүүнийтэгшитгэлийн талаар

Асуудал 3

Төрийн өмчит үйлдвэрийн газруудын ашиг, алдагдлын талаар

Асуудал 4

Санхүүгийн тайлагнал, аудитаар илэрсэн зөрчил дутагдлын талаар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг. Түүнд дотоод хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон Үндэсний аудитын газрын санхүүгийн аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь Батлан хамгаалах яамны хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм

Тиймээс зөвлөмжүүд маань дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний ойлголтыг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Батлан хамгаалах яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Х.Батсүх, Ерөнхий нягтлан бодогч Ө.Даваадорж болон бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дарааллаар дурдвал:

- Цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлууд;
- Удирдлагын анхаарах шаардлагатай асуудлууд;

Асуудал 1 Авлага, өр төлбөрийн баталгаажилтын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Батлан хамгаалахын сайдын хамрах хүрээний байгууллагуудын дүнгээр авлага өмнөх оноос 43.0 хувиар буюу 1,370.0 сая төгрөгөөр буурсан хэдий ч өр төлбөр өмнөх оноос 3,080.2 сая төгрөгөөр өссөн, нийт авлагын 31.4 хувь буюу 33 байгууллагатай холбоотой 321.4 сая төгрөгийн авлага, нийт өр төлбөрийн 2.7 хувь буюу 131.2 сая төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд нийт авлага, өр төлбөрийн дүн үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдэд буруу ташаа мэдээлэл өгөх;

ҮАГ-ын зөвлөмж

“Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 19.1.4 “Эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлж, харилцагч аж ахуйн нэгж, байгууллагатай хоорондын тооцоогоор үүссэн авлага, өр төлбөрийг улирал, жилийн эцэс бүрт тооцоо нийлж актаар баталгаажуулах.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу хөөн хэлэлцэх хугацаа дууссан найдваргүй авлагыг данс бүртгэлээс хасах асуудлыг эцэслэн шийдвэрлэх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2014 оны 12 дугаар сарын 15-ны дотор ҮАГ-т ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллах болно.

ҮАГ-ын ажиглалт

Батлан хамгаалахын сайдын 2012 оны А/121 дүгээр тушаалаар Транс сэргэлт ТӨҮГ-ын валютын харилцах дансанд байршиж байсан гэрээний урьдчилгаа төлбөрийн 2,070.0 мянган ам.долларыг тухайн үеийн ханшаар тооцон 2,716.3 сая төгрөгийг Зэвсэгт хүчний хөгжлийн санд шилжүүлэн урьдчилж орсон орлогоор бүртгэсэн байна. Тус сангийн 2013 оны санхүүгийн тайлангийн аудитаар валютын ханшийн өөрчлөлтөөс үүсэх эрсдэлээс сэргийлж, Монголбанкны жилийн эцсийн албан ханшаар тооцон ханшийн зөрүүгийн алдагдал 719.1 сая төгрөгийг нэмж тооцсоноор 3,435.2 сая төгрөгийг бусад өглөг дансанд залруулах бичилт хийлгэн бүртгүүлсэн болно.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журмын дагуу үнэн, шударга илэрхийлэгдэхгүй байх, өр төлбөрийг эргүүлэн төлөх үед ханшийн эрсдэл үүсэх;

ҮАГ-ын зөвлөмж

Өглөгийг эргэн төлөгдөх хүртэл жил бүр валютын ханшийн тэгшитгэл хийж бүртгэл тайланд тусгаж байх;

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллах болно.

ҮАГ-ын ажиглалт

Батлан хамгаалахын сайдын 2012 оны А/121 дүгээр тушаалаар Транс сэргэлт ТӨҮГ-ын валютын харилцах дансанд байршиж байсан гэрээний урьдчилгаа төлбөрийн 2,070.0 мянган ам.долларыг тухайн үеийн ханшаар тооцон 2,716.3 сая төгрөгийг Зэвсэгт хүчний хөгжлийн санд шилжүүлэн урьдчилж орсон орлогоор бүртгэсэн байна. Тус сангийн 2013 оны санхүүгийн тайлангийн аудитаар валютын ханшийн өөрчлөлтөөс үүсэх эрсдэлээс сэргийлж, Монголбанкны жилийн эцсийн албан ханшаар тооцон ханшийн зөрүүгийн алдагдал 719.1 сая төгрөгийг нэмж тооцсоноор 3,435.2 сая төгрөгийг бусад өглөг дансанд залруулах бичилт хийлгэн бүртгүүлсэн болно.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журмын дагуу үнэн, шударга илэрхийлэгдэхгүй байх, өр төлбөрийг эргүүлэн төлөх үед ханшийн эрсдэл үүсэх.

ҮАГ-ын зөвлөмж

Өглөгийг эргэн төлөгдөх хүртэл жил бүр валютын ханшийн тэгшитгэл хийж бүртгэл тайланд тусгаж байх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллах болно.

ҮАГ-ын ажиглалт

Тайлант онд Бөртэ ТӨҮГ 595.1 сая төгрөг, Багабаян-Энхийн төлөө цогцолбор төв 11.5 сая төгрөгийн ашигтай ажилласан бол, Транс сэргэлт ТӨАҮГ 2012 онд 30.0 сая, 2013 онд 64.7 сая төгрөгийн, Монгол цэрэг констракшн ТӨҮГ 2012 онд 9.8 сая, 2013 онд 689.8 сая төгрөгийн, Барилга захиалагчийн алба 2013 онд 59.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, алдагдлын хэмжээ өмнөх жилээс өссөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Батлан хамгаалах яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Санхүү, хөрөнгө оруулалтын газрууд хамтран харьяа ТӨҮГ-уудын ашиг, алдагдлын өсөлт, бууралтын шалтгаан, нөлөөллийг шалгаж, үр ашгийг дээшлүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2014 оны 12 дугаар сарын 15-ны дотор ҮАГ-т ирүүлэх;

Эрсдэлүүд

Санхүүгийн үр ашиг буурах, өмч хөрөнгө үнэгүйдэх, хөрөнгийн ашиглал шамшигдал үүсэх, зардлын хяналт алдагдах;

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллах болно.

ҮАГ-ын ажиглалт

Аудитаар Транс сэргэлт, Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨҮГ-уудын санхүүгийн тайланд “хязгаарлалттай”, Монгол цэрэг жуулчин ТӨҮГ-ын санхүүгийн тайланд “сөрөг”, бусад байгууллагуудын санхүүгийн тайланд “зөрчилгүй” санал дүгнэлт өгөгдсөн.

Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 3,637.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 46 зөвлөмж өгөгдөж, 12,527.4 сая төгрөгийн зөрчилд залруулга хийгдсэн байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журмын дагуу үнэн, шударга илэрхийлэгдэхгүй байх.

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн болон хараат бус аудитын байгууллагуудаас төсвийн шууд, төвлөрүүлэн, ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангуудад хийсэн аудитаар илэрсэн алдаа зөрчлүүдэд дүгнэлт хийж, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийг мөрдлөг болгон, салбар нэгжүүдийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.

Аудитаар хязгаарлалттай, сөрөг дүгнэлт авсан, материаллаг шинжтэй зөрчил гаргасан байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудад Төрийн аудитын тухай хуулийн 7.28.1-д заасны дагуу хариуцлагын арга хэмжээ тооцох.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2014 оны 12 дугаар сарын 15-ны дотор ҮАГ-т ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллах болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн хавсралт

| д/д | Аудитаар илэрсэн зөрчил | Өгсөн зөвлөмж | Биелэлт | Биелэлт % |
|--|---|--|--|-----------|
| Батлан хамгаалахын сайдын төсвийн багцын санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн зөвлөмж | | | | |
| 1 | Батлан хамгаалахын сайдын төсвийн багцын дүнгээр 2012 оны батлагдсан төсвийг нийт дүнгээр 5,941.5 сая төгрөг буюу 3.7 хувиар хэмнэлттэй зарцуулсан хэдий ч Зэвсэгт хүчний анги салбаруудын төсвийн төлөвлөлтийг хийхдээ үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг тусгайлан төлөвлөөгүй, урсгал төсвийн хамт нэгтгэн төлөвлөсөн, орлогын төлөвлөгөөний биелэлт, төсвийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүйгээс зарим анги, салбар, байгууллагууд батлагдсан төсвийг зардлын зүйл ангиар 1.9-90.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна | Сангийн сайдын 2010 оны 48 дугаар тушаалаар баталсан "Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам"-ыг мөрдөн, төсөвт зардлыг батлагдсан хуваарь, зүйл ангийн дагуу зарцуулж, зардлын гүйцэтгэл, төлөвлөгөөний биелэлтэд тавих дотоод хяналтыг сайжруулах | Салбарын батлагдсан төсвийн сарын санхүүжилтийн хуваарийг сайдын тушаалаар баталгаажуулан төсөвт байгууллагуудад хүргүүлэн төсвийн зарцуулалтад төрийн сангийн үйл ажиллагаа болон төсвийн мэдээнд үндэслэн хянаж, баталсан хууль тогтоомжийн дагуу төсвийг зарцуулах шаардлага тавин ажиллаж байна. | 90.0 |
| 2 | Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Үйлчилгээ аж ахуйн хэлтсийн хэрэглэж буй түлш халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир усны зардлын нийт 230.2 сая төгрөгийн төлбөрийг нэгдсэн нэг тоолуураар хийж байгаа нь байгууллага тус бүрийн бодит гүйцэтгэлийг орхигдуулж, тэдгээрийн төлөвлөлтийн үндэслэлийг бодитой бус болгож байна. | Зардлын төлөвлөлтийн үндэслэлийг бодитой болгох, зардлыг байгууллага тус бүрийн гүйцэтгэлээр тооцдог тогтолцоонд шилжих, удирдлагаас тавих дотоодын хяналтыг сайжруулах | Тогтмол зардлыг бодит гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж, тухайн байгууллагуудын төсөвт суулган хуваарилах арга хэмжээ авсан. | 80.0 |
| 3 | ЗХХСангийн хөрөнгөөс яамны үүдний танхим, Зэвсэгт хүчний анги салбаруудын урсгал болон их засвар, тохижилтод | Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 32.1-д заасан "Тусгай сангийн хөрөнгийг | 2012 онд ХБНГУ-аас олгосон буцалтгүй тусламжийн 30 нэгж авто техникүүдийг хүлээн авах тээврийн зардалд 265.8 сая | 80.0 |

| | | | | |
|---|--|---|---|-------|
| | 1,294.0 сая төгрөг, тусламжаар ирүүлсэн техник тоног төхөөрөмжийн тээврийн зардалд 715.5 сая төгрөг, Гадаад улсад суугаа батлан хамгаалахын атташегийн албанд шаардагдах тавилга хэрэгсэл, автомашины үнэд 63.4 сая төгрөгийг тус тус зарцуулжээ. | батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно.” 25.1.2.4 “Энхийг дэмжих ажиллагаанд оролцохтой холбогдсон бусад үйл ажиллагааг санхүүжүүлэх” заалтуудыг мөрдөж ажиллах. | төгрөг, БНСУ-аас олгосон буцалтгүй тусламжийн 104 нэгж авто техникүүдийг хүлээн авах тээврийн зардалд 449.7 сая төгрөг зарцуулсан. Уг зардлууд нь урсгал төсөвт тусгагдаагүй байсан бөгөөд Зэвсэглэл техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах арга хэмжээ байсан тул сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх үндэслэлтэй юм. Зэвсэгт хүчний анги салбаруудын урсгал болон их засвар, тохижилтын ажилд 1,294.0 сая төгрөг зарцуулсан. Энэ нь тухайн анги салбарын сургалтын орчин нөхцөл, материаллаг баазыг бэхжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ тул сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх үндэслэлтэй болно. | |
| 4 | БХС-ын 2011 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 81 дүгээр тушаалаар бэлтгэл болон чөлөөнд гарсан генерал цолтнуудад эдлэн газрыг орон сууцны хамт олгож байх, холбогдох зардлыг ЗХХС-аас гаргахаар шийдвэрлэж нийт 324.1 сая төгрөгийг зарцуулсан байна. | Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 25.2.6-ийн “Батлан хамгаалах салбарт ажиллаж байгаа офицер, ахлагч, албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах” заалтыг мөрдөж ажиллах | Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 25.2.6-ийн “Батлан хамгаалах салбарт ажиллаж байгаа офицер, ахлагч, албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах” заалтын дагуу нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн. | 100.0 |
| 5 | ЗХЖШ-ын харъяа Зэвсэгт хүчний анги салбарууд 2005 оноос “Ординат” ХХК-ийн “Виница-3.1” программ ашиглаж байгаа боловч суурилуулснаас хойш бүртгэлд орсон өөрчлөлтүүдийг хийгээгүй, програмын ашиглалт болон түүн дээр ажиллах анги салбаруудын нягтлан бодогч нарын мэдлэг чадвар харилцан адилгүй | СЭЗСайдын 2009 оны 171 дүгээр тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан тодруулгын маягтууд санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлал”-ын дагуу салбарын хэмжээний санхүүгийн тайланг нэгтгэн гаргаж байхаар санхүүгийн програмд өөрчлөлт, | Санхүүгийн тайлангийн нэгтгэлийн Plastic програмд шинээр батлагдсан журам зааварт нийцүүлэн шинэчлэлтийг тухай бүр суулгуулан тайлангийн нэгтгэлийг тус програмаар хийж байна. Зэвсэгт хүчний нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн | 100.0 |

| | | | | |
|---|--|---|---|-------|
| | <p>байна.</p> <p>Зарим анги салбарууд энэ жилээс эхлэн компьютер ашиглан нягтлан бодох бүртгэл хөтөлж байгаа бөгөөд, компьютер техник хэрэгслийн хүчин чадал муу, антивирусын программгүй байна.</p> | <p>шинэчлэлт оруулах.</p> <p>2013 оны эхний хагаст багтаан салбарын хэмжээнд санхүүгийн програм хангамжийн ашиглалт, нягтлан бодогч нарын ур чадварыг сайжруулах арга хэмжээ авч, хэрэгжилтийг мөн оны 11 дүгээр сарын 20-ны дотор УАГ-т ирүүлэх.</p> | <p>мөрдүүлэхтэй холбогдуулж Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн арга зүйн газар, Улсын секторын санхүү, бүртгэлийн институт, Санхүүгийн тооцоолох төвтэй хамтран Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын санхүүгийн дарга, тооцооны нягтлан бодогч нарын мэргэжлийн сургалтыг 2013 оны 04 дүгээр сарын 22-ноос 24-ны өдрүүдэд зохион байгууллаа.</p> <p>Зэвсэгт хүчний нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөх, Зэвсэгт хүчний ангиудын нягтлан бодох бүртгэл, мэдээлэл, тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэхийн тулд өндөр түвшиний санхүүгийн хэрэглээний програмаар боловсруулах зорилгоор Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох төв” ХХК-ны “ACOLOUS” санхүүгийн програмыг 2013 оны 1 дүгээр сараас эхлэн ашиглаж байна.</p> | |
| 6 | <p>2006 онд Батлан хамгаалах салбарын агентлаг, харъяа анги, салбар, байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар”-ыг БХЯ, ЗХЖШ-ын Санхүүгийн хэлтсээс боловсруулан мөрдөж байгаа боловч уг бодлогын баримт бичигт харъяа салбар байгууллагуудын үйл ажиллагааны онцлог болон мөн Төсвийн тухай хууль,</p> | <p>2012 онд шинээр батлагдсан төсвийн тухай хууль, УСНББОУС-ын өөрчлөлт, СЭЗСайдын 2006 оны 388, 2008 оны 352, 2009 оны 171 дүгээр тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг батлуулан мөрдөж ажиллах.</p> | <p>Төсвийн тухай хууль, УСНББОУС, Сангийн сайдын баталсан зарим аргачлал заавар, журмын өөрчлөлтийг тусгасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан сайдын 2013 оны А/146 дугаар тушаалаар баталгаажуулан төсөвт байгууллагуудад хүргүүлэн мөрдөн ажиллаж байна.</p> | 100.0 |

| | | | | |
|--|---|--|--|--|
| | УСНББОУС, Сангийн сайдын баталсан зарим аргачлал заавар, журмын өөрчлөлтийг бүрэн тусгаагүйгээс шинэчлэх шаардлагатай болсон байна. | | | |
|--|---|--|--|--|

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2013 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ | ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ | ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ | АУДИТЫН ЗАЛРУУЛГА | АУДИТ ХИЙГДСЭН ҮЛДЭГДЭЛ |
|--|---------------------------|---------------------------|----------------------|-------------------------------|
| МӨНГӨН ХӨРӨНГӨ | 5,257,470,255.78 | 5,307,616,996.41 | | 5,307,616,996.41 |
| Кассанд байгаа бэлэн мөнгө | 2,334,699.86 | 27,956,708.31 | | 27,956,708.31 |
| Төгрөг\ ЖМС | 2,334,699.86 | 27,956,708.31 | | 27,956,708.31 |
| Банкинд байгаа бэлэн мөнгө | 5,255,135,555.92 | 5,279,660,288.10 | | 5,279,660,288.10 |
| Төгрөг | 5,255,135,555.92 | 5,279,660,288.10 | | 5,279,660,288.10 |
| Орон нутгийн харилцах | 20,701.74 | 42,685.35 | | 42,685.35 |
| Төсөвт байгууллагын харилцах | 3,584,251,483.58 | 4,054,709,452.07 | | 4,054,709,452.07 |
| Төсөвт байгууллын харилцах (Арилжааны банк) | 1,670,863,370.60 | 1,218,559,293.99 | | 1,218,559,293.99 |
| Нэмэлт санхүүжилтийн харилцах | - | 6,348,856.69 | | 6,348,856.69 |
| АВЛАГА | 2,402,194,138.74 | 1,032,127,301.21 | | 1,032,127,301.21 |
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 3,715,406.00 | 1,393,606.00 | | 1,393,606.00 |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 104,024,170.28 | - | | - |
| Бусад авлага | 2,294,454,562.46 | 1,030,733,695.21 | | 1,030,733,695.21 |
| Байгууллагаас авах авлага | 1,883,917,800.70 | 638,077,296.73 | | 638,077,296.73 |
| Бусад зардлын тооцооны авлага | 1,883,917,800.70 | 638,077,296.73 | | 638,077,296.73 |
| Хувь хүмүүсээс авах авлага | 410,536,761.76 | 392,656,398.48 | | 392,656,398.48 |
| УРЬДЧИЛГАА | 6,769,866,901.84 | 15,006,975,714.37 | | 15,006,975,714.37 |
| Бусад урьдчилгаа | 6,769,866,901.84 | 15,006,975,714.37 | | 15,006,975,714.37 |
| Урьдчилгаа тооцоо | 400,000.00 | 12,383,106,511.01 | | 12,383,106,511.01 |
| Бараа материал бэлтгэх урьдчилгаа | 400,000.00 | 272,468,732.01 | | 272,468,732.01 |
| Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа | - | 12,110,637,779.00 | | 12,110,637,779.00 |
| Урьдчилж гарсан зардал | 6,769,466,901.84 | 2,623,869,203.36 | | 2,623,869,203.36 |
| Урьдчилж төлсөн зардал | 6,769,466,901.84 | 2,623,869,203.36 | | 2,623,869,203.36 |
| БАРАА МАТЕРИАЛ | 164,352,299,632.43 | 162,024,155,377.31 | | 162,024,155,377.31 |
| Түүхий эд материал | 35,014,503,302.50 | 28,204,324,792.76 | | 28,204,324,792.76 |
| Тусгай зориулалттай материал | 4,021,863,874.94 | 5,708,456,528.27 | | 5,708,456,528.27 |
| Эм боох материал | 676,882,254.29 | 884,618,370.76 | | 884,618,370.76 |
| Дуусаагүй үйлдвэрлэл | 19,546,434,016.78 | 11,514,009,592.00 | | 11,514,009,592.00 |
| Бэлэн бүтээгдэхүүн | 10,769,323,156.49 | 10,097,240,301.73 | | 10,097,240,301.73 |
| Хангамжийн материал | 127,883,527,964.88 | 132,040,247,168.56 | | 132,040,247,168.56 |
| Бичиг хэргийн материал | 1,889,447,953.32 | 1,947,112,114.19 | | 1,947,112,114.19 |
| Аж ахуйн материал | 1,983,607,512.74 | 2,107,571,020.21 | | 2,107,571,020.21 |
| Сэлбэг хэрэгсэл | 46,705,428,938.43 | 45,926,933,685.41 | | 45,926,933,685.41 |
| Түлш, шатах тослох материал | 3,693,457,904.20 | 3,921,441,924.68 | | 3,921,441,924.68 |
| Барилгын засварын материал | 2,785,436,774.99 | 3,756,840,442.77 | | 3,756,840,442.77 |
| Хүнсний материал | 2,121,399,915.26 | 2,050,351,176.80 | | 2,050,351,176.80 |
| Малын тэжээл | 54,510,774.98 | 50,726,731.98 | | 50,726,731.98 |
| Баглаа боодол | 60,268,393.29 | 65,043,005.76 | | 65,043,005.76 |
| Бусад бараа материал | 68,589,969,797.67 | 72,214,227,066.76 | | 72,214,227,066.76 |
| Мал амьтад | 1,454,268,365.05 | 1,779,583,415.99 | | 1,779,583,415.99 |
| НӨӨЦ | 13,274,614,335.14 | 13,197,540,126.19 | | 13,197,540,126.19 |
| Барааны нөөц | 13,274,614,335.14 | 13,197,540,126.19 | | 13,197,540,126.19 |

| | | | | |
|--|---------------------------|---------------------------|--|---------------------------|
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 192,056,445,263.93 | 196,568,415,515.49 | | 196,568,415,515.49 |
